

# Удирдагчийн хөтөч

## үс Библи судлалын хэрэглээ

Энэхүү Библи судлал нь удирдагчдад Судрыг сонирхолтой бөгөөд олон талт байдлаар судлах замаар бүлгээ удирдах боломжийг өгнө. Библийг энгийн арга замаар гүнзгийрүүлэн судлах тус арга бүх насны болон итгэлийн хувьд харилцан адилгүй түвшний хүмүүст Бичвэрийг ганцаарчлан болон бүлгээр судлахад урамшуулдаг.

Энэ бол оролцогч өдөр бүр Бичвэрийн нэг хэсгийг бие даан судалж, бүлгийн уулзалт болон дараа долоо хоногийн хэлэлцүүлэгт бэлтгэх сургалтын заавар юм.

Оролцогчид өдөр бүр бичвэрийн хэсгээс уншиж, ойлголтын төлөө залбирч, өдөр тутмын асуулгыг гүйцээнэ. Ариун Сүнс өдөр тутамдаа бичвэрийн гүнзгий утгыг илчлэн мөн ухаарлыг өгдөг. Улмаар оролцогчид Бурханы Үгийг идэвхтэй судалж сурах бөгөөд Библи судлалын доорх энгийн аргыг ашиглан өөрчлөлт шинэчлэлийг дагуулагч Бурханы үнэнийг нээж мөн амьдралдаа хэрэгжүүлнэ

- **Ажиглалт**  
Бичээс юу хэлж байна вэ?  
Гол санаа нь юу вэ?
- **Тайлбар**  
Бичээс ямар утгатай вэ?  
Бичвэрт ямар чухал үгс, илэрхийлэл, болон үнэн агуулагдаж байна вэ?
- **Хэрэгжүүлэлт**  
Ариун Сүнс Бичвэр дэх эл үнэнийг амьдралдаа хэрэгжүүлэх тухайд хэрхэн чиглүүлж байна вэ?

## Библи судлалыг эхлүүлэхүй

Өнө мөнхийн нөлөөллийг бий болгохын тулд Бурхан таны мөн чанар, амьдарч буй газар, ажил, эсвэл нийгмийн хүрээллийг ашиглахыг хүсдэг гэж бид итгэдэг. Дараах алхмуудаар эхэлье:

### 1. ЗАЛБИРАЛ

... бүгд залбирал ба харилцаагаар эхэлдэг.

## **ЗАЛБИРАЛ**

- Библи судлалын бүлгийг эхлэхэд тань туслах найзынхаа төлөө залбираарай.
- Хамтдаа тогтмол залбир. Бурханы төлөвлөгөө болон удирдамжийг асуу.
- Орон нутагтаа алхмын залбирал хий. Бурханы ерөөл болон хамгаалалтыг хүсэн залбир.
- Хүмүүсийн төлөө залбирахдаа нэрээр нь дуудаж залбир. Тэдэнтэй уулзах, тэднийг халамжлах, тэдэнд үйлчлэх боломжийн төлөө Бурханаас гуйн залбир. Нээлттэй зүрх сэтгэл болон харилцааг босгон байгуулах үйлдэл хий.
- Тэд Библи судлах хүсэл сонирхолтой байхын төлөө залбир.

## **ХАРИЛЦАА**

- Таны ойролцоо амьдардаг, ажилладаг, эсвэл нийгмийн хүрээлэлд тань багтдаг хүмүүстэй уулзаарай. Тэдэнд нөхөрсөг хандаж, тэднийг урамшуул.
- Харилцан яриаг эхлүүл – зөв асуулт тавьж, сайн сонсогч бай.
- Хамт цай, кофе уух эсвэл хооллох зэргээр цагийг хамтдаа өнгөрөө.
- Хайрлах, өгөх, үйлчлэх боломжуудыг эрэлхийл.

## **2. ХОЛБОГД**

... *Оролцох сонирхолтой хүмүүсийг ол.*

## **ЦУГЛАРАЛТЫГ ТӨЛӨВЛӨ**

- Өдөр, цаг, газраа сонго.
- Оролцуулахыг хүсэж буй хүмүүсийн жагсаалт гарга.
- Залбираад тэднийг уриарай.
- Хэрэв боломжтой бол амын зугаа гаргах бага сага зүйл бэлтгээрэй.
- Цугласан хүмүүстэй харилцан яриа өрнүүлэх асуултын жагсаалт эсвэл “танилцуулах” төлөвлөгөө гарга.

## **ЦУГЛАРАЛТЫН УДИРДАМЖ**

- Боломжтой бол кофе, цай, эсвэл амын зугаа гаргах идэх зүйл бэлтгэ.
- Угтаж ав, өөрийгөө танилцуулж мөн бусдад өөр хоорондоо танилцах боломж олго (асуулт эсвэл тоглоом ашигла).
- Цаг дуусах үед дараах зүйлтэй утга дүйх зүйлийг хэлээрэй: *“Бид цагийг сайхан өнгөрөөлөө. Хамтдаа Библи судалж, бичвэр дэх үнэн хувь хүний маань амьдралд ямар хамааралтайг олж нээдэг аюулгүй, бие биеэ урамшуулсан орчин бүрдүүлэхийг би зорьж байна. Хэрэв та сонирхож байгаа бол надад хэлээрэй.”*

## **3. УДИРДАХ**

... *одоо эхлээрэй.*

- Сургалтын хөтчийг татаж аваад, хүн тус бүрд зориулан хэвэл.
- Сургалтын хөтчөөр санал болгосон Бичээсийн дөрвөн алхмын нэгийг сонгоорой.
- Оролцогчдод өдөр бүрийн асуултуудын хариултаа бичих жижиг тэмдэглэлийн дэвтэртэй хэрэгтэй.

## **Библи судлалын бүлгийг удирдахуй**

Товч залбирлаар эхэл.

- Судлалын сэдэв болох ГЭРЭЛ сэдвийн дагуу бэлтгэсэн удиртгал түүхийг унш.
- Хэн нэгнээр Бичээсийг уншуул.
- Судлалын хөтөч дэх асуултуудын дагуу хэлэлцүүлгийг удирд.
- Хүмүүсийн хариултыг хүлээн хэсэг зуур чимээгүй байхад зүгээр. Хэлэлцүүлгийг гол зорилго бол хүмүүс ярих болохоос удирдагч бүх хариултыг хэлэх биш гэдгийг санаарай.

Бүлгийн хэлэлцүүлгийг идэвхтэй өрнүүлэхийн тулд зарим нэг дараах чухал заавруудыг сануулж байх хэрэгтэй.

- Бүх хүнд сонсогдохоор чанга ярь.
- Товч мэдэгдлээр хариул, нуршихгүй байхыг хичээ.
- Хэлэлцүүлгийг Христ болон Библи төвтэй байлга.
- Сэдэв дээрээ төвлөрч, маргаантай асуудлаас зайлсхий.

Ариун Сүнс Бурханы Үгийг хариуцдаг, хүн бүрийн амьдралд оролцдог бөгөөд бидний амьдралын нөхцөл байдал, сүнслэг өсөлтийг тус бүрчлэн мэддэг. Тиймээс хүн бүрд тусгайлан заах, хэрэгжүүлэлд хөтлөх зүйл Түүнд бий гэдгийг бүлэгтээ сануулаарай.

- Судлалын төгсгөлд дараагийн долоо хоногт судлах Бичвэрийн хэсгийг тогт.
- Библи судлалын цагтаа бусдыг урих нь найрсаг бөгөөд элэгсэг орчин бүрдүүлдэг тул бүлэгт найз нөхдөө урихад урамшуулан ятгаарай.
- Товчхон залбирлаар дуусга.

Библи судлалаа илүү өргөжүүлэхэд туслах нэмэлт асуултууд.

- Бурхан танд өөр юу заасан бэ?
- Та хариултаа илүү дэлгэрүүлж болох уу?
- Энэ хариулт дээр нэмж санал хэлэх хүн байна уу?
- Уг эшлэлээс юу танд илүү гүнзгий сэтгэгдэл төрүүлэв?

### **Удиртгал:**

Яст мэлхийн олон төрөл зүйлд устаж үгүй болох аюул тулгараад байгаа билээ. Энэ аюул араатан амьтад, хүн, эсвэл байгалийн бохирдлоос болж үүсээгүй. Харин далайн эрэг дагуух их хэмжээний хиймэл гэрлээс үүдэлтэй аж.

Бурхан далайн яст мэлхийнүүдийг сарны гэрэлд төрдөг байхаар бүтээсэн. Бяцхан яст мэлхий өндөгний хальсаа хагалсан гарч ирээд сарны гэрлээр замчлуулан далайн усанд ордог. Далайн яст мэлхийн амьдрал усанд бий.

Долгионтон туссан сарны гэрэл болон далайн эрэг дээрх амралтын газруудын утсан гэрлүүд, замын гэрэл, авто машины гэрлүүдийн тусгалын завсарт үхсэн байсан бяцхан яст

мэлхий судлаачдын гайхширлыг түрүүлсэн юм. Хиймэл гэрлүүдийн улмаас төөрөгдөн замаа алдах нь далайн яст мэлхийнүүдийг үхэл рүү хөтөлдөг аж.

Энэ хүү Библи судлал таныг Есүсийн няцаашгүй гэрэлд хөтлөх болно. “Би бол ертөнцийн гэрэл мөн... харин амийн гэрэлтэй болно гэж айлдав.”(Иохан 8:12) Гэрэл мөн таныг Түүний Үг рүү хөтлөх болно. – “Миний  
“ Таны үг бол миний хөл дэх дэнлүү,  
Миний зам дахь гэрэл юм.” (Дуулал 119:105) харанхуй ертөнц дэх Христийн гэрэл болоход таныг хүчжүүлнэ. “Та нар бол дэлхийн гэрэл мөн. Уулан дээрх хот нуугдаж үл чадна”(Матай 5:14).

Та өдөр бүр Бурханы Үгийг уншиж, бясалгаж, амьдралдаа хэрэгжүүлэх аваас муу нэгний хуурамч гэрлийг ялган таньж, Бурханы гэрэл-замыг дагах бөгөөд гэр бүл, хамт олныхоо дунд Христийн хурц гэрэл болж гэрэлтэх болно. Есүсийн амьдрал, харилцаа, гайхамшиг болон сургаалд суурилсан дөрвөн Гэрэлийг гүнзгий судлаарай.

